



ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Үндэсний аудитын газрын нэгдсэн төлөвлөгөө, аймгийн аудитын газрын 2018 оны бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөл

“НЭГДСЭН ЭМНЭЛГИЙН 2016-2017 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН”



АМБУЛАТОРИЙН ҮЗЛЭГИЙН ЦАГ ОЛГОЛТ АЖЛЫН ЦАГИЙН
ХУВААРИЙН ДАГУУ ОЛГОГДОХГҮЙ БАЙНА.

Тайланг бэлтгэсэн:	Товчилсон үгийн жагсаалт.....3 Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй.....4-5
Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газар	БҮЛЭГ-1
Газрын дарга, тэргүүлэх аудитор Ч.Чүлтэмбат	1.1. Төсвийн орлого, зарлагын төлөвлөгөөг үндэслэлтэй төлөвлөж байна6-8 1.2.Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулжээ.....8-9
Аудитын менежер Ш.Мөнхбаяр	БҮЛЭГ-2
Ахлах аудитор С. Батцэцэг	2.1 Иргэдэд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг үзүүлэх орчин нөхцөл хэвийн байна.....10-11 2.2. Эмч, эмнэлгийн ажилчдын хүний нөөцийн бүрдүүлэлт, хүрэлцээ зохих түвшинд хангагдсан боловч стандарттай уялдаагүй байна..... 11-14 2.3.Эмч, сувлагчдын мэргэжлийн дагуух давхар хөдөлмөр эрхлэлт нь тус эмнэлгийн үйлчилгээний чанарт сөрөг нөлөө үзүүлж болзошгүй байна..... 14-15 2.4. Нэгдсэн эмнэлэг эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлэх шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангагдаагүй байна..... 15-16
Аудитор С. Санжаажав Г.Батмягмар	
2018 оны 08 дугаар сар	БҮЛЭГ-3
Аудитын тайлантай холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 7037-3089, 7037-4605 дугаарын утсаар харилцана уу.	3.1. Төсвийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагаа тус эмнэлэгт зохион байгуулагдаагүй байна 16 3.2.Үндсэн хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, ашиглалтын байдал хэвийн байна..... 16-17 3.3. Үндсэн хөрөнгө, бараа материалыг холбогдох хууль, журмын дагуу акталж, устгажээ..... 17
ХАЯГ:	БҮЛЭГ-4
Дархан-Уул аймгийн Дархан сум, 14-р баг, Аймгийн ЗДТГ-ын байр, 306 тоот	4.1. Байгууллагын дотоод хяналт, түүний үр дүн хангалтгүй байна..... 18 4.2. Санхүүгийн хяналт, аудитын албанаас өгсөн зөвлөмжийн биелэлт 42.8 хувьтай байна..... 18-19 4.3. Нэгдсэн эмнэлэг 2018 оны 457.4 сая төгрөгийн мэдээллийг шилэн дансанд байршуулаагүй байна..... 19
	ДҮГНЭЛТ.....20 ЗӨВЛӨМЖ.....21

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
БГАҮ	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ
БҮТЭЗ	Бага үнэтэй түргэн элэгдэх зүйл
ГА	Гүйцэтгэлийн аудит
ДАА	Дархан-Уул аймаг
ДОХ	Дархлалын олдмол хомсдол
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ЗХУ	Зөвлөлт холбоот улс
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
НББ	Нягтлан бодох бүртгэл
ТАГ	Төрийн аудитын газар
ТБОНӨХБАҮХА	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах
ТХ	Тээврийн хэрэгсэл
УИХ	Улсын их хурал
ҮАГ	Үндэсний Аудитын газар
ЭМД	Эрүүл мэндийн даатгал
ЭМЯ	Эрүүл мэндийн яам
ЭМНДХ	Эрүүл мэнд нийгмийн даатгалын хэлтэс
ЭЭО	Эмчилгээ эрхэлсэн орлогч

АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ

Аудитыг Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан “Аудитын төлөвлөгөө, сэдэв батлах тухай” 2018 оны 1 дүгээр сарын 8-ны өдрийн А/06 дугаар тушаал, Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газрын 2018 онд нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд хийв.

Аудитын зорилт

Аймгийн Нэгдсэн эмнэлгийн үйл ажиллагааны үр дүнд үнэлэлт дүгнэлт өгч, зөвлөмж боловсруулан, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдлээ. Уг зорилтыг хангахын тулд дараах асуудлаар аудитыг гүйцэтгэв. Үүнд:

- Төсвийн орлого, зарлагыг үндэслэлтэй төлөвлөж, батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж буй эсэх
- Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх орчин нөхцөл, хүний нөөц, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангагдсан эсэх
- Хөрөнгийн худалдан авалт, ашиглалт, хамгаалалт үр дүнтэй байгаа эсэх
- Дотоод хяналтын тогтолцоо үр дүнтэй байгаа эсэх

Хамарсан хүрээ

Аудитад аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2016, 2017 оны үйл ажиллагааг хамруулан гүйцэтгэлээ.

Үндсэн мэдээлэл

Дархан-Уул аймагт 1963 онд 50 ортой дундын эмнэлэг байгуулагдсан ба 1966 онд 105 ортой нэгдсэн эмнэлэг болон өргөжжээ.

1972 онд тухайн үеийн ЗХУ-ын тусламжаар баригдсан 240 ортой 400 хүнд үйлчлэх хүчин чадалтай поликлиник, 40 ортой халдвартын тасаг, лаборатори, физик эмчилгээний кабинет, гал тогоо, автограж, шүүх эмнэлэг, эмгэг анатомийн корпустай, бүрэн тоног төхөөрөмжтэй ашиглалтад орсон байна.

Дархан-Уул аймгийн Нэгдсэн эмнэлэг нь одоогоор 377 ортой, 23 тасаг нэгжтэй, нийт 529 ажилтантай, үүнээс 115 их эмч, 11 гүйцэтгэх ажилтан, 286 дунд мэргэжилтэн, 117 үйлчилгээний ажиллагсадтайгаар эмнэлгийн тусламж үйлчилгээг үзүүлж байна.

Эмч нараас клиникийн профессор 5, тэргүүлэх зэрэгтэй 21, ахлах зэрэгтэй 21, тэргүүлэх зэрэгтэй эм зүйч 1, анагаах ухааны болон боловсролын магистр 16 их эмч, сувилагч байна.

Аудитын арга зүй

Аудитыг гүйцэтгэхдээ гүйцэтгэлийн аудитын удирдамж /АДБОУС 3000-3100/, гүйцэтгэлийн аудитын журмыг ашиглах бөгөөд холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа болон судалгаа авах, баримт материалуудад дүн шинжилгээ хийх, тулган баталгаажуулах, давтан шалгах, нэгтгэх зэрэг арга зүйг ашиглан, асуудлын шинжилгээний дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн, дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

Шалгуур үзүүлэлт

Аудитын зорилттой холбоотой дараах хууль эрхийн актыг аудитын шалгуур үзүүлэлтийн эх сурвалж болгон ашиглалаа. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Эрүүл мэндийн тухай хууль
- Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хууль
- НББ-ийн тухай хууль
- ТБОНӨХБАҮХА тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль
- Төрийн аудитын тухай хууль
- Холбогдох бусад хууль тогтоомж, эрхийн акт

БҮЛЭГ 1

Төсвийн орлого, зарлагыг үндэслэлтэй төлөвлөж, батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулжээ.

1.1. Төсвийн орлого, зарлагын төлөвлөгөөг үндэслэлтэй төлөвлөж байна.

Аймгийн Нэгдсэн эмнэлэг 2016 онд 8,474.0 сая төгрөг батлуулснаас 8,458.2 сая төгрөг зарцуулж, 15.8 сая төгрөгийн, 2017 онд 8,767.2 сая төгрөг батлуулснаас 8,744.0 сая төгрөг зарцуулж, 23.2 сая төгрөгийн хэмнэлттэй ажиллажээ.

2016-2017 оны нийт орлогын 58.4-58.9 хувийг улсын төсвөөс, 39.3-39.8 хувийг ЭМД-ын сангаас, 1.7-1.8 хувийг өөрийн орлогоор тус тус бүрдүүлсэн байна.

Эх үүсвэр	2016 он			2017 он		
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
Улсын төсөв	4,994.1	4,982.9	(11.2)	5,133.2	5,107.2	(26.0)
ЭМД-ын сан	3,334.5	3,325.8	(8.7)	3,488.5	3,481.4	(7.1)
Өөрийн орлого	145.4	149.5	4.1	145.5	155.4	9.9
Дүн	8,474.0	8,458.2	(15.8)	8,767.2	8,744.0	(23.2)

Улсын төсвийн санхүүжилт тайлант онуудад бүрэн орж ирсэн бөгөөд 2016 онд 11.2 сая, 2017 онд 26.0 сая төгрөгийн зарцуулаагүй үлдэгдлийг буцаан төвлөрүүлсэн байна.

Даатгалтай иргэдийн бичиг баримт болон өвчний түүхийн зөрчлийн улмаас ЭМД-ын сангийн санхүүжилт 7.1-8.7 сая төгрөгөөр хасагджээ.

Харин өөрийн орлогыг 2016 онд 102.7 хувиар, 2017 онд 106.8 хувиар тус тус биелүүлсэн байна.

Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны 470 дугаар тушаалаар “Төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагаас үзүүлэх төлбөртэй тусламж, үйлчилгээний жагсаалт”, “Төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагаас үзүүлэх төлбөртэй тусламж, үйлчилгээний журам”-ыг тус тус баталсан. Эрүүл мэндийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.3¹ болон дээрх журмын 3.2.1²-т зааснаар төлбөртэй тусламж, үйлчилгээний төлбөрийн жишиг хэмжээг Сангийн сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан тушаалаар батлахаар заасан ч одоог хүртэл батлаагүй тул ерөнхий эмчийн тушаалаар төлбөртэй үйлчилгээний төлбөрийн хэмжээг тогтоожээ.

Нэгдсэн эмнэлэг өөрийн орлогоор эмнэлгийн тусламж, үйлчилгээ, эрүүл мэндийн дүгнэлт гаргах, архивын лавлагаа өгөх, хог хаягдал, ариутгал, шарил хадгалалт, түрээс зэрэг орлогуудыг төлөвлөж, төвлөрүүлдэг бөгөөд өөрийн орлогын төлөвлөлтийг үндэслэлтэй хийсэн байна.

¹ Төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагаас үзүүлэх төлбөртэй тусламж, үйлчилгээний журам, жагсаалтыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, төлбөрийн жишиг хэмжээг санхүүгийн болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.

² Сангийн сайд, Эрүүл мэнд, спортын сайдын хамтарсан тушаалаар батлагдсан төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагаас үзүүлэх төлбөртэй тусламж, үйлчилгээний төлбөрийн жишиг хэмжээ

Төсвийн зарцуулалтыг он тус бүрээр харуулбал дараах байдалтай байна.

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	2016 он			2017 он		
	төлөвлөгөө	гүйцэтгэл	зөрүү	төлөвлөгөө	гүйцэтгэл	зөрүү
Цалин хөлс	5,544.9	5,540.3	(4.6)	5,491.0	5,485.7	(5.3)
НД-ын шимтгэл	611.0	610.5	(0.5)	606.5	606.5	0.0
Тогтмол зардал	295.4	288.2	(7.2)	330.1	321.2	(8.9)
Гэрэл цахилгаан	85.5	87.9	2.4	85.2	83.2	(2.0)
Түлш, халаалт	104.1	98.7	(5.4)	117.1	113.6	(3.5)
Цэвэр, бохир ус	105.8	101.6	(4.2)	127.8	124.4	(3.4)
Хангамж, бараа материал	143.5	143.5	0.0	145.8	145.8	0.0
Бичиг хэрэг	3.4	4.6	1.2	3.2	4.2	1.0
Тээвэр шатахуун	87.2	83.6	(3.6)	91.3	82.8	(8.5)
Шуудан холбоо	4.2	1.4	(2.8)	4.8	1.6	(3.2)
Хог хаягдал зайлуулах	39.5	41.6	2.1	42.4	44.9	2.5
БҮТЭЗ	9.2	12.3	3.1	4.1	12.3	8.2
Нормативт зардал	1,769.0	1,769.0	0.0	1,902.5	1,902.5	0.0
Эм бэлдмэл	1,480.0	1,524.4	44.4	1,641.7	1,654.5	12.8
Хоол хүнс	249.9	205.5	(44.4)	219.5	206.7	(12.8)
Нормын хувцас	39.1	39.1	0.0	41.3	41.3	0.0
Эд хогшил худалдан авах	61.3	58.1	(3.2)	80.5	80.5	0.0
Багаж хэрэгсэл	13.3	9.3	(4.0)	42.8	42.8	0.0
Тавилга	16.8	6.9	(9.9)			
Хөдөлмөр хамгаалал	2.1	0.0	(2.1)	2.0	0.0	(2.0)
Урсгал засвар	29.1	41.9	12.8	35.7	37.7	2.0
Дотоод албан томилолт	1.1	1.1	0.0	2.4	1.8	(0.6)
БГАҮ-ний төлбөр	47.8	47.5	(0.3)	53.0	52.3	(0.7)
БГАҮ	19.6	19.4	(0.2)	19.8	19.6	(0.2)
Аудит, баталгаажуулалт	4.1	4.1	0.0	5.8	5.4	(0.4)
Даатгалын үйлчилгээ	1.6	1.6	0.0	4.7	4.7	0.0
ТХ-ийн татвар	0.7	0.7	0.0	0.7	0.7	0.0
ТХ-ийн оношилгоо	0.3	0.3	0.0	0.3	0.3	0.0
Газрын төлбөр	2.1	2.1	0.0	2.1	2.1	0.0
Банкны хураамж	0.2	0.1	(0.1)	0.2	0.1	(0.1)
Маягт хэвлэх, бэлтгэх	19.2	19.2	0.0	19.4	19.4	0.0
Нэг удаагийн тэтгэмж				155.4	147.7	(7.7)
Нийт дүн	8,474.0	8,458.2	(15.8)	8,767.2	8,744.0	(23.2)

Зардлыг бүлгийн дүнгээр авч үзвэл цалин хөлс 4.6-5.3 сая, тогтмол зардал 7.2-8.9 сая, эд хогшил худалдан авах зардал 3.2 сая, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж 0.3-0.7 сая, нэг удаагийн тэтгэмж урамшууллыг 7.7 сая төгрөгөөр тус тус хэмнэжээ.

Харин зардлын ангиллаар харахад зарим хэтэрсэн зардлуудыг бүлэг дотроо гүйлгэн зарцуулсан байлаа. Тухайлбал:

- Эмийн зардлыг 2016 онд 2,081.3 сая, 2017 онд 1,827.9 сая төгрөгөөр төсөвлөж өгсөн ч яамнаас зардлыг бууруулан баталсан байв. Сүүлийн жилүүдэд манай аймагт хүн амын нягтаршил ихсэж, тэр хэмжээгээр өвчлөл нэмэгдэж байгаатай холбоотойгоор эмийн хэрэглээ өсжээ. Эмийн зардлын төсөв хүрэлцэхгүйгээс бүлэг дотроо хоол хүнсний зардлаас хэмнэгдсэн зардлыг гүйлгэн зарцуулдаг байна.

- Түргэн тусламжийн автомашин, оношилгооны аппарат, тоног төхөөрөмж хуучирч, байнга эвдрэл гарч, засвар үйлчилгээ хийх шаардлагатай байдгаас бүлэг доторх хэмнэгдсэн зардлаас урсгал засварын зардалд 2016 онд 12.8 сая, 2017 онд 2.0 сая төгрөгийг гүйлгэн зарцуулжээ.
- Шуудан холбоо, тээвэр шатахууны зардлаас хэмнэсэн мөнгийг бичиг хэрэг, бага үнэтэй түргэн элэгдэх зүйл, хог хаягдал зайлуулах зардалд гүйлгэн зарцуулсан байв.

Харин ажиллагсад цалингүй чөлөө их авч байгаагаас цалингийн зардал, байгууллагын телефон утасны тоог цөөрүүлэн, ярианы хэрэглээг хязгаарлаж, тасаг нэгжүүдийг дотоод сүлжээнд оруулснаар шуудан холбооны зардал, ажиллагсдын шилжилт хөдөлгөөн их байдгаас нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардал тус тус хэмнэгдсэн байна.

Түүнчлэн хэвтэн эмчлүүлэгчдийн тоо төлөвлөсөн хэмжээнд хүрээгүйгээс хоолны зардал 2016 онд 44.4 сая, 2017 онд 12.8 сая төгрөгөөр хэмнэгдсэн байна. Хэвтэн эмчлүүлэгчдийн тоог дараах хүснэгтээр харуулья.

Огноо	Хэвтэн эмчлүүлэгчдийн тоо /мянган хүн/		
	төлөвлөгөө	гүйцэтгэл	зөрүү
2016 он	146.9	120.0	26.9
2017 он	129.1	121.6	7.5

Хоолны хэмнэгдсэн зардлыг эмийн зардалд гүйлгэн зарцуулж болдог, эмийн зардлын төсөв хүрэлцдэггүй, байнга дутагдалтай байдаг байна.

Нэгдсэн эмнэлэг 2016-2017 онд тогтмол зардлыг 7.2-8.9 сая төгрөгөөр хэмнэсэн бөгөөд хоолны зардал, тогтмол зардлаас бусдаар төсвийн зарцуулалтын төлөвлөлтийг үндэслэлтэй хийсэн байна гэж дүгнэлээ.

1.2. Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулжээ.

Дархан-Уул аймгийн Нэгдсэн эмнэлгийн төсвийн зарлага 2016 онд 8,458.2 сая, 2017 онд 8,744.0 сая төгрөг байна.

Цалингийн зардлыг хянаж үзэхэд 2016 онд батлагдаагүй орон тоонд бичиг хэргийн ажилтан – архивын, онош зүйн тасгийн их эмч – цитолог эмчийн, дурангийн их эмч – тасгийн эрхлэгчийн, ДОХ-ын кабинетийн их эмч – тасгийн эрхлэгчийн, онош зүйн тасгийн эрхлэгч – бактериологи лабораторийн эмчийн, тоног төхөөрөмжийн инженер – хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан ажилтны албан тушаалуудыг хавсран гүйцэтгэжээ. Харин 2017 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн А/01 тоот ерөнхий эмчийн тушаалаар дээрх алдаа зөрчлийг залруулж, орон тоог баталсан байлаа.

Санхүүгийн хяналт, аудитын алба 2017 оны 06 дугаар сард тус эмнэлгийн ерөнхий эмч, эмчилгээ эрхэлсэн орлогч, хүний нөөцийн менежер, чанарын албаны дарга нарын тасгуудад жижүүр хийсний илүү цагийн хөлсийг үндсэн ажлын албан тушаалын цалингаас тооцож олгож байгаад 2.9 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, цаашид илүү цагийн хөлсийг эмчийн албан тушаалын цалингаас тооцож олгох зөвлөмжийг өгчээ. Гэвч Нэгдсэн эмнэлэг илүү цагийн хөлсийг үндсэн ажлын

албан тушаалын цалингаас тооцсон хэвээр байна. Дээрх албан тушаалтнууд нь тасгуудад жижүүр эмчийн үүргийг гүйцэтгэхдээ үндсэн ажлаа илүү цагаар гүйцэтгээгүй, эмчийн үүргийг гүйцэтгэж ажиллаж байгаа тул Хөдөлмөрийн тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.1-д *“Ажилтны цалин хөлсийг хийснээр, цагаар, бусад хэлбэрээр хөдөлмөрийн үр дүнд нь тохируулан олгоно”* гэж заасны дагуу илүү цагийн хөлсийг эмчийн албан тушаалын цалингаас тооцож олгох нь зүйтэй байна.

Түүнчлэн нийт ажиллагсдын ээлжийн амралтын тооцоог хийхдээ Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайдын 2000 оны 166 тоот тушаалаар баталсан **“Ээлжийн амралтын олговор тооцох журам”**-ын 5-д заасан *“Ажилтны ажилласан хугацаа 12 сар хүрээгүй бол түүний ээлжийн амралтын олговрыг ажилласан хугацааны дундаж цалин хөлсөөр тооцно”* гэснийг зөрчиж, дундаж цалин хөлсийг тооцохдоо ажиллаагүй хугацааг оруулан тооцсон байв. Үүнд ээлжийн амралтын олговрыг нөхөн олгуулахаар 14.9 сая төгрөгийн төлбөрийн акт тавигдлаа.

Мөн УИХ-ын 2017 оны 67 дугаар тогтоолоор төрийн албан хаагчдад үр дүнгийн урамшуулал олгохоор баталсан бөгөөд Засгийн газрын 2017 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн хуралдааны 52 дугаар тэмдэглэлд *сахилгын шийтгэл хүлээсэн бөгөөд сахилгын шийтгэлгүйд тооцох хугацаа нь дуусаагүй байгаа албан хаагчаас бусад төрийн албан хаагчдад мөнгөн урамшуулал олгох арга хэмжээ авахыг төсвийн шууд захирагч нарт даалгасан.* Гэвч тус байгууллагын эмч Д.Ариунболд, Ж.Эрдэнэчимэг, Б.Молор-Эрдэнэ нар ажлын хариуцлага алдаж, сахилгын шийтгэл хүлээсэн ба сахилгын шийтгэлгүйд тооцох хугацаа нь дуусаагүй байхад 656756 төгрөгийн мөнгөн урамшуулал олгосонд төлбөрийн акт тогтоосон болно.

Тус эмнэлгийн 2016, 2017 оны ерөнхий дэвтрээс төсвийг зориулалтын дагуу ангилж бүртгэснийг тулган шалгахад 2016 онд 0.9 сая төгрөгийн хог тээвэрлэлтийн зардлыг тээвэр шатахууны зардалд оруулан бүртгэсэн нь Сангийн сайдын 2014 оны 55 дугаар тушаалаар баталсан *“Төсвийн зарлагын эдийн засгийн ангилал”*-тай нийцээгүй байна.

Нэгдсэн эмнэлгийн санхүүгийн үйл ажиллагаанд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төсвийн тухай хуулийн хэрэгжилт болон нягтлан бодох бүртгэл хөтлөлт хэвийн бөгөөд төсвийг зориулалтын дагуу зарцуулжээ.

БҮЛЭГ 2

Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг үзүүлэх орчин нөхцөл, хүний нөөцийн хүрэлцээ зохих түвшинд хангагдсан боловч зарим шаардлагатай тоног төхөөрөмжүүд дутагдалтай байна.

2.1. Иргэдэд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх орчин нөхцөл хэвийн байна.

Аймгийн Нэгдсэн эмнэлэг нь 8 блок 9,016.17 кв талбай бүхий эмнэлгийн барилга байгууламж, 23 тасаг нэгж, 377 ортойгоор эмнэлгийн тусламж үйлчилгээг үзүүлж байна. Эмнэлгийн тусламж үйлчилгээг чанартай, түргэн шуурхай, хүртээмжтэй хүргэх, үйлчилгээний орчин нөхцөлийг тохижуулах талаар эмнэлгийн удирдлага, тасаг хамт олны зүгээс тодорхой ажлуудыг санаачлан хийж хэрэгжүүлжээ. Тухайлбал:

- 2016 онд 7.9 сая төгрөгийн тохижилтийн ажил хийгдсэн бөгөөд үүний 4.3 сая төгрөгийг төсвийн хөрөнгөөр, 3.6 сая төгрөгийг хандив, тусламжаар хийжээ. Үүнээс Поликлиникийн тасгийн хамт олны санаачилгаар Б.Дамдиндорж захиралтай “Бүрэн” тавилгын цехээс заалны сандлуудыг хийж, хандивласан нь иргэдийг тав тухтай үйлчлүүлэх томоохон ажлуудын нэг болсон байв.
- 2017 онд 22.3 сая төгрөгийн тохижилтын ажил хийгдсэнээс төсвийн хөрөнгөөр 20.3 сая төгрөг, хандиваар 2.03 сая төгрөгийн ажил тус тус хийгдсэн байна.

Мөн эмнэлгийн ажилтнуудын ажлын байрны орчин нөхцөлийг сайжруулах, амрах өрөөг тохижуулах зэрэг ажлуудыг хийсэн байна.


Харин эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилгоор иргэдээс санал авах хайрцаг ажиллуулдаг боловч тогтмол шалгаж үздэггүй байна. Тодруулбал амбулатори болон поликлиникийн тасагт байрлуулсан саналын хайрцгийг нээж үзэхэд эмнэлгийн үйлчилгээ, нэр бүхий эмч, сувилагчдын хүнд суртал, харилцааны ёс зүйтэй холбоотой 2015, 2016, 2018 оны санал, гомдлууд байв. Иймд саналын хайрцгаар ирсэн санал хүсэлтийг тодорхой хугацаанд авч, тэдгээрт дүн шинжилгээ хийн, гарсан зөрчлийг арилгах арга хэмжээ авч ажиллахад анхаарах нь зүйтэй.

Эрүүл мэндийн сайдын 2014 оны 13 дугаар тушаалаар батлагдсан судалгааны маягтын дагуу Нэгдсэн эмнэлгийн чанарын албанаас эмч, сувилагч, амбулатороор үйлчлүүлэгч болон хэвтэн эмчлүүлэгчдээс авсан судалгааны төрөл тус бүрээс 70 оролцогчийн судалгааг санамсаргүй сонголтоор авч нэгтгэв.

Судалгаанаас байгууллагын дотоод орчны соёл, тав тух гэсэн асуултын хариуг нэгтгэж харуулбал:

/хувиар/				
№	Үзүүлэлт	Сайн	Дунд	Муу
1	Эмч, эмнэлгийн ажилтнууд	48.6	44.3	7.1
2	Амбулатороор үйлчлүүлэгчид	54.3	40.0	5.7
3	Хэвтэн эмчлүүлэгчид	71.4	27.2	1.4
Дундаж үзүүлэлт		58.1	37.2	4.7

Харин аудитын явцад амбулатороор үйлчлүүлэгч болон хэвтэн эмчлүүлэгчдээс судалгаа авахад дараах байдалтай байлаа.



Дээрх судалгаа, санал асуулгын нэгтгэл зэргээс харахад эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг үзүүлэх орчин нөхцөлийг бүрдүүлж чадсан байна гэж дүгнэж байна.

Тус эмнэлэг, үйлчлүүлэгчдийн хувьд тулгамдаж буй асуудал нь амбулаторийн хэсгийн агааржуулалт юм. Тухайн хэсэгт үйлчлүүлэгчид олноор цуглардаг учраас бүгчим халуун, тав тух муутай байдаг байна. Иймд эмчлүүлэгч, үйлчлүүлэгчдийн тав тухтай үйлчлүүлэх орчин нөхцөлийг бүрдүүлэх үүднээс агааржуулалт зайлшгүй хийх шаардлагатай байна.

2.2. Эмч, эмнэлгийн ажилчдын хүний нөөцийн бүрдүүлэлт, хүрэлцээ зохих түвшинд хангагдсан боловч стандарттай уялдаагүй байна.

Нэгдсэн эмнэлэг нь нийт 529 ажилтантай. Хүний нөөцийг бүрдүүлэх, тэдгээрийг сонгон шалгаруулж авахдаа ерөнхий эмчийн баталсан “Нэгдсэн эмнэлгийн ажилтан сонгон шалгаруулах журам”-ыг мөрдлөг болгон ажиллаж иржээ.

Сонгон шалгаруулалт явуулахдаа 3 шатлал, 8 шалгуур үзүүлэлтээр мэдлэг, ур чадварын шалгалт авч, хамгийн өндөр оноо /75-аас дээш/ авсан иргэнийг тэнцсэнд тооцож, хөдөлмөрийн гэрээ байгуулах эрх үүсдэг байна. 2018 оны 06 дугаар сарын байдлаар хүний нөөцөд бүртгэлтэй нийт 77 иргэн байгаа бөгөөд эдгээрийг мэргэжлээр нь авч үзвэл их эмч 9, сувилагч 33, бусад 35 байна.

Үндэсний статистикийн хорооноос гаргадаг судалгаанаас 21 аймгийн Эрүүл мэндийн салбарт ажиллаж байгаа нэг эмч, сувилагчид ногдох хүний тоог 2016, 2017 оноор харьцуулахад аймгуудын дунджаас нэг их эмчид ногдох хүний тоо 42-66, нэг сувилагчид ногдох хүний тоо 20-32-оор тус тус бага байна. Харин их эмчийн тоо аймгуудын дунджаас 77-93-аар их байна.

Дээрх тоон үзүүлэлт болон хүний нөөцөд бүртгэлтэй иргэдийн судалгаа зэргээс харахад хүний нөөцийн бүрдүүлэлт, хүрэлцээ зохих түвшинд хангагдсан гэж үзэж байна.

Хүний нөөцийн хөгжлийг хангах, чадавхийг бэхжүүлэх талаар байгууллагын зүгээс тогтмол анхаарч гадаад, дотоодын сургалтад хамруулж иржээ. Тухайлбал: 2016 онд гадаад сургалтад 17 эмч, дотоод мэргэжил дээшлүүлэх сургалтад 63 эмч, эмнэлгийн мэргэжилтэн хамрагдсан бол 2017 онд гадаад сургалтад 8 эмч, дотоодын сургалт, туршлага судлахад 9 эмчийг тус тус хамруулсан байв. Үүнээс гадна ажлын байрны сургалтад давхардсан тоогоор 2016 онд 1020, 2017 онд 3442 эмч, эмнэлгийн ажилтан хамрагджээ.

Иргэд, үйлчлүүлэгчдээс 2016-2017 онд эмнэлгийн тусламж үйлчилгээ, эмч, сувилагчдын ёс зүйтэй холбоотой нийт 44 өргөдөл, гомдол ирүүлснийг ангилж үзвэл дараах байдалтай байна. Үүнд:


- 38 нь буюу 86.4 хувь нь эмч, сувилагч нар ёс зүйгүй харьцдаг /хэл амаар доромжлох, загнах/, ажлын цагаар ажлын байрандаа байдаггүй, буруу онош тавьдаг үүнээс болж бие, сэтгэл зүйгээр хохирсон, нярай эндсэн гэх мэт.

- 6 нь буюу 13.6 хувь нь эмнэлгийн үйл ажиллагааны талаар. Тухайлбал: цахим бүртгэл, эмнэлгийн багаж хэрэгсэл, ЭМДаатгал гэх мэт.

Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийг шалгаж үзэхэд баримт бичгийн эмх цэгц, бүрдүүлэлт хангалтгүй, шийдвэрлэсэн байдал нь тодорхой бус, холбогдох баримтаар нотлогдохгүй байв. Энэ нь иргэд, үйлчлүүлэгчдээс төрийн байгууллага, албан тушаалтанд итгэх итгэлийг бууруулах, эмнэлгийн байгууллага, ажилтнуудын нэр хүндэд муугаар нөлөөлөх зэрэг сөрөг үр дагавартай юм.

Мөн аудитын явцад тус эмнэлгээр үйлчлүүлэгчдээс авсан судалгааны дүнг зургаар харуулбал:

(Зураг: №3)





Иргэдийн өргөдөл, гомдол болон дээрх судалгаанаас дүгнэхэд амбулатороор үйлчлүүлэгчдийн хувьд эмч, эмнэлгийн ажилтнуудын ёс зүй, цаг ашиглалтад сэтгэл хангалуун бус байгааг харуулж байна. Мөн цахим бүртгэлээс амбулаторийн үзлэгийн цаг олголт, үзлэг хийлгэсэн хүний тоог эмч тус бүрээр гаргахад өдөрт нэг эмч дунджаар 6-38 хүнд үзлэг хийсэн бол цаг олголт нь ажлын цагийн хуваарийн дагуу олгогддоггүй байна. Тухайлбал ажлын цагийн хуваарь 8.00-14.00 байхад эрүү нүүрний эмчийн үзлэг 8.20-11.30, шүдний эмчийн үзлэг 8.00-12.30 хооронд олгогдсон бол 8.00-16.30 цаг хүртэл ажиллах ёстой дуран оношилгооны эмчийн үзлэг 8.00-12.30 хооронд цаг олгосон байв.

Иймд эмч, эмнэлгийн ажилтнуудын ажлын хариуцлага, ёс зүй, цаг ашиглалт, бүртгэлийг сайжруулахад онцгой анхаарах шаардлагатай байна.

Монгол Улсын Стандарт, хэмжил зүйн газраас нэгдсэн эмнэлгийн бүтэц, үйл ажиллагааны стандартыг тогтоож, Стандартчиллын үндэсний зөвлөлийн тогтоолоор баталдаг бөгөөд 2002, 2013, 2017 онд тус тус шинэчлэгдэн батлагдсан байна.

Аудитын хамрах хугацаанд Стандартчиллын үндэсний зөвлөлийн 2013 оны 12 дугаар сарын 19-ны өдрийн 63 дугаар тогтоолоор батлагдсан MNS 5095:2013 стандартаар зааж өгсөн норматив шаардлагыг заавал мөрдөж ажиллахыг тусгаж өгсөн байв. Уг стандартаар аймгийн Нэгдсэн эмнэлэг нийт 623 орон тоотой ажиллахаар байгаа боловч 2016, 2017 онуудад 460 орон тоо баталж өгчээ.

Батлагдсан орон тоог гүйцэтгэлтэй харьцуулбал:

Үзүүлэлт	Батлагдсан	Гүйцэтгэлээр	Зөрүү	
Нийт орон тоогоор	2016 он	460	534	74
	2017 он	460	529	69

Харин гүйцэтгэлээрх орон тоог тухайн үеийн стандарттай харьцуулбал:

Үзүүлэлт	Албан тушаал	Гүйцэтгэлээр		Стандартаар / MNS 5095: 2013 /	Зөрүү	
		2016 он	2017 он		2016 он	2017 он
Удирдах ажилтан	Ерөнхий эмч	1	1	1	0	0
	ЭЭО дарга	1	1	1	0	0
Дүн		2	2	2	0	0
НЭМ-ийн мэргэжилтэн	Хүний нөөцийн менежер	1	1	5	4	4
	Чанарын албаны дарга	1	1		-1	-1
	Статистикч	1	1		-1	-1
	Эм зүйч	4	5	5	1	0
Дүн		7	8	10	3	2
Эмч, эмнэлгийн мэргэжилтэн	Их эмч	102	100	100	-2	0
	Сувилагч	212	203	248	36	45
	Эмнэлгийн тусгай мэргэжилтэн	82	80	82	0	2
Дүн		396	383	430	34	47
Бусад ажилтан	Мэдээлэл технологийн инженер	1	1	2	1	1
	Эмнэлгийн тоног техөөрөмжийн инженер	2	1	2	0	1
	Бусад мэргэжилтэн	6	4	11	5	7
	Бусад ажилтан	120	130	166	46	36
Дүн		129	136	181	52	45
Нийт дүн		534	529	623	89	94

Дээрх харьцуулсан судалгаануудаас харахад батлагдсан болон гүйцэтгэлээрх орон тоо нь тухайн үед мөрдөгдөж байсан стандарттай уялдаагүй байна.

2.3. Эмч, сувилагчдын мэргэжлийн дагуух давхар хөдөлмөр эрхлэлт нь тус эмнэлгийн үйлчилгээний чанарт сөрөг нөлөө үзүүлж болзошгүй байна.

Тус эмнэлгийн эмч, эмнэлгийн мэргэжилтэн мэргэжлийн дагуу давхар ажил, хөдөлмөр эрхэлж байгаа талаар судлан үзэхэд 8 их эмч, 2 эм зүйч, 1 эх баригч хувийн хэвшлийн байгууллагад ажиллаж байна.

Давхар ажил эрхлэлт нь эмнэлгийн тусламж үйлчилгээний чанарт хэрхэн нөлөөлж байгаа талаар судалгаа авахад судалгаанд оролцогчдын 22.8 хувь нь үйлчлүүлсэн эмч, эмнэлгийн мэргэжилтэн хувийн эмнэлэг, эмийн сан санал болгосон гэж хариулсан байна. Мөн нэгдсэн эмнэлгийн чанарын албанаас авсан судалгаанаас харахад судалгаанд оролцогчдын (санамсаргүй сонголтод хамрагдсан 70 үйлчлүүлэгч) 22.8 хувь нь тийм (эмч, эмнэлгийн мэргэжилтэн нь

хувийн эмнэлэг, эм, эмийн сан, сүлжээ санал болгодог, хувиасаа эм зардаг) гэж хариулсан бол 48.6 хувь нь үгүй, 31.4 хувь нь мэдэхгүй гэж хариулжээ.

Дээрх судалгаанаас дүгнэж үзвэл эмч, эмнэлгийн мэргэжилтэн мэргэжлийн дагуу давхар ажил, хөдөлмөр эрхэлж байгаа нь эмнэлгийн үндсэн үйл ажиллагаанд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй байна.

2.4. Нэгдсэн эмнэлэг эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлэх шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангагдаагүй байна.

Аудитаар MNS 5095:2013 стандартад заасан тоног төхөөрөмжийг тус эмнэлэгт байгаа тоног төхөөрөмжтэй харьцуулахад 754 ширхэг тоног төхөөрөмжийн дутагдалтай байна. Үүнээс төсөв хүрэлцэхгүйн улмаас дутагдалтай 679, шаардлагатай биш 53, одоо байгаа нь хүрэлцээтэй 22 тоног төхөөрөмж байна. Нэгдсэн эмнэлэг шаардлагатай тоног төхөөрөмжийг авахад зориулж төсвийн төслийг боловсруулахдаа тооцож өгдөг ч яамнаас баталж өгдөггүй байна. Тухайлбал 2016 онд 1,017.2 сая төгрөгийн нэн шаардлагатай тоног төхөөрөмжийн судалгааг гаргаж өгсөн байв.

Түүнчлэн 2016 оны эцэст Эрүүл мэндийн яамнаас нэгдсэн эмнэлгийн тоног төхөөрөмжийн ашиглалт, үйл ажиллагаатай танилцан, тоног төхөөрөмжийн хангамжийн байдал хангалтгүй гэж дүгнэсэн байлаа. Тус ажлын хэсэг нэгдсэн эмнэлэгт доорх асуудлуудыг шийдвэрлэхийг даалгасан байна:

- ✓ Моргийн хөргөгч нийт 14 ажиллахаас 4 ажиллаж байгаа тул зуны улирлаас өмнө яаралтай шийдвэрлүүлэх
- ✓ Физик эмчилгээний тоног төхөөрөмжийг шинэчлэх
- ✓ Флюорографийн аппаратыг шинэчлэх
- ✓ Компьютер томографийн аппараттай болох /Хувийн байгууллагын аппарат түрээсээр байрладаг/
- ✓ Вакум хагалгааны өрөөг засварлах

Аудитаар яамны ажлын хэсгээс өгсөн үүрэг даалгаврын биелэлттэй танилцахад:

- Моргийн хөргөгчнүүдэд засвар хийж, 4 хөргөгчний мотор, 1 хөргөгчний моторын сэнсийг сольж, 2 хөргөгчинд перон шахаж, 7 хөргөгч ажиллагаанд оруулжээ. Одоогийн байдлаар 3 хөргөгч эвдрэлтэй байна.
- Физик эмчилгээний тоног төхөөрөмжийн хувьд ашиглалтын хугацаа дууссан, жил бүрийн захиалгад оруулдаг боловч нийлүүлдэггүй. 2017 онд ЭМЯ-наас УВЧ-30 маркийн шарлагын аппарат ирүүлжээ.
- Флюорографийн аппарат нь 1986 онд ирсэн тоног төхөөрөмж ашиглалтын хугацаа дуусаж, жил бүрийн тоног төхөөрөмжийн захиалга болон ЭМЯ-д санал хүсэлт явуулдаг боловч хариу ирүүлээгүй байна. 2018 оны 03 сард рентген хоолой шатсаныг сольж ажиллагаанд оруулсан байв.
- Компьютер томографийн аппаратыг жил бүрийн захиалгад оруулдаг боловч хариу ирээгүй байна.

- Вакум хагалгааны өрөөний дотор агааржуулалтын сэнс буруу байрласнаас болж систем хэт халж релин болон мотор шатсаныг моторын ороомог ороолгож, дулааны релин, автомат сольсон. Одоо хэвийн ажиллагаатай болсон бөгөөд уг аппаратны сэнсийг гадаа байршуулахгүй бол дахин шатах эрсдэлтэй байна.

Мөн Нэгдсэн эмнэлэгт эмнэлгийн тоног төхөөрөмжийн 6 инженер, 2 техникч ажиллахаас 2 инженер, 1 мэргэжилтэн ажиллаж байгаа бөгөөд ажлын байр, засварын газар, ажлын багаж, туслах хэрэгсэл хангалтгүй байна.

БҮЛЭГ 3

Хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, ашиглалтын байдал хэвийн байна.

3.1. Төсвийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагаа Нэгдсэн эмнэлэгт зохион байгуулагдаагүй байна.

Аудитын хамрах хугацаанд Нэгдсэн эмнэлгийн бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг аймгийн худалдан авах ажиллагааны алба болон орон нутгийн өмчийн газар зохион байгуулсан байна. Тус үйл ажиллагааг “Улсын төсвийн хөрөнгө оруулалтын хэрэгжилт, үр дүн” гүйцэтгэлийн аудитаар үзсэн болно.

3.2. Үндсэн хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, ашиглалтын байдал хэвийн байна.

Дархан-Уул аймгийн Нэгдсэн эмнэлэгт 2017 оны жилийн эцсийн байдлаар 11,588.4 сая төгрөгийн барилга байгууламж, 798.3 сая төгрөгийн авто тээврийн хэрэгсэл, 5,163.2 сая төгрөгийн тоног төхөөрөмж, 220.0 сая төгрөгийн тавилга эд хогшил, 25.5 сая төгрөгийн бусад хөрөнгө, 4.7 сая төгрөгийн ном, 19.7 сая төгрөгийн биет бус хөрөнгө бүртгэлтэй байна. /анхны өртгөөр/

Аудитаар тус эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженер Энх-Амгалантай хамтран бүх тасаг нэгжүүдээр явж, хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, ашиглалтын байдалтай танилцахад хөрөнгүүд бүртгэлд бүрэн тусгагдсан, зориулалтын дагуу хэвийн ашиглагдаж байна. Түүнчлэн хөрөнгүүдийн хувийн хэргийг зохих журмын дагуу хөтөлсөн, тасаг нэгжүүдэд хариуцуулж хаягжуулсан байв.

Харин тус эмнэлэгт:

- ✓ Биохимийн анализатор хуурай
- ✓ Колон тоологч
- ✓ Биохимийн анализатор
- ✓ Бүлэгнэлтийн бүрэн автомат анализатор
- ✓ Тариурын автомат шахуурга гэсэн тоног төхөөрөмжүүдийн

ажиллагаа хэвийн боловч лабораторийн 4 тоног төхөөрөмжийн шинжилгээ хийх урвалж, оношлуурын өртөг өндөр, төсөв мөнгө хүрэлцдэггүй, харин тариурын автомат шахуургад таарах тариур үйлдвэрлэгдэхээ больсноос ашиглагддаггүй байна.

Мөн ЭМЯ-наас цахим эмнэлгийн төсөл бүрэн хэрэгжээгүй байгаагаас 150 ширхэг 60.1 сая төгрөгийн тог баригч, 2 ширхэг 1.6 сая төгрөгийн зураасан код хэвлэгч, 4 ширхэг 2.6 сая төгрөгийн зураасан код уншигч, 1 ширхэг 15.8 сая төгрөгийн дугаар зохицуулах систем зэрэг төхөөрөмжүүд одоогоор ашиглаагүй байна.

3.3. Үндсэн хөрөнгө, бараа материалыг холбогдох хууль, дүрэм, журмын дагуу акталж устгасан байна.

Тус эмнэлэг эд хөрөнгийн тооллогыг жилд 2 удаа хийдэг бөгөөд тооллогын комисс ашиглах хугацаа дууссан, эсвэл ашиглах хугацаа дуусаагүй боловч эвдрэл гэмтлийн улмаас зориулалтаар нь ашиглах боломжгүй болсон хөрөнгүүдийн жагсаалтыг гаргадаг байна. Байгууллагын өмч хамгаалах зөвлөл акталж, устгах хөрөнгүүдэд дүгнэлт гаргаж, эргэлтийн хөрөнгийг ерөнхий эмчийн тушаалаар, үндсэн хөрөнгийг аймгийн ИТХ-ын тогтоолоор акталжээ.

Ерөнхий эмчийн 2016 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн А/29 тоот тушаалыг үндэслэн 225 нэр төрлийн 1242 ширхэг 19.9 сая төгрөгийн, 2016 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн А/51 тоот тушаалыг үндэслэн 151 нэр төрлийн 554 ширхэг 12.3 сая төгрөгийн, 2017 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн А/32 тоот тушаалыг үндэслэн 165 нэр төрлийн 1036 ширхэг 22.5 сая төгрөгийн, 2017 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн А/66 тоот тушаалыг үндэслэн 228 нэр төрлийн 2520 ширхэг 29.8 сая төгрөгийн БҮТЭЗ, зөөлөн эдлэл, жижиг багаж зэргийг тус тус данснаас хасаж, зохих журмын дагуу устгалд оруулсан байна.

2016 онд аймгийн Өмч хамгаалах байнгын зөвлөлийн шийдвэрээр 8 нэр төрлийн 7.1 сая төгрөгийн тоног төхөөрөмж, 10 нэр төрлийн 1.9 сая төгрөгийн тавилга эд хогшил, 0.4 сая төгрөгийн биет бус хөрөнгө акталжээ.

Түүнчлэн яаралтай тусламжийн TIANMA SUV 72-03 ДАР, FOTON 63-60 ДАР, БЕНЗ 01-03 ДАА дугаар бүхий автомашинуудыг аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн 2016 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн 52 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2016 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн А/209 тоот захирамжийг үндэслэн үндсэн хөрөнгөнөөс хассан байна.

Харин аймгийн өмч хамгаалах байнгын зөвлөлийн 2017 оны 07 дугаар сарын 24-ний өдрийн хуралдаанаас 107.6 сая төгрөгийн үнэ бүхий үндсэн хөрөнгийг устгахаар шийдвэрлэж, Орон нутгийн өмчийн газрын 2017 оны 08 дугаар сарын 07-ны өдрийн 290 тоот албан бичгийн дагуу 50 нэр төрлийн 103.3 сая төгрөгийн тоног төхөөрөмж, 18 нэр төрлийн 4.3 сая төгрөгийн тавилга эд хогшил, навчит мод зэргийг тус тус акталж, мөн зургаар баталгаажуулж ажилласан байлаа.

БҮЛЭГ 4**Байгууллагын дотоод хяналт үр дүнгүй байна.****4.1. Байгууллагын дотоод хяналт, түүний үр дүн хангалтгүй байна.**

Монгол Улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийн дотоод хяналт шалгалтыг аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага хэрэгжүүлнэ”, 18.2-д “Дотоодын нягтлан бодох бүртгэлийн хянан шалгаагчийг аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага томилж болно” гэж заасан байна.

Тус эмнэлгийн ерөнхий эмчийн 2015 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн А/16 тоот, 2016 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн А/38 тоот, 2017 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн А/13 тоот тушаалуудаар дотоод хяналтын багийг томилж, ажиллах журмыг баталжээ.

2016-2017 онуудад дотоод хяналт шалгалтын жилийн төлөвлөгөөг гарган ажилласан боловч санхүү, нягтлан бодох бүртгэлийн чиглэлээр дотоод хяналтыг хэрэгжүүлээгүй байна.

Дотоод хяналтын баг нь тасгуудад мөрдөгдөж буй оношилгоо, эмчилгээний стандарт, эрүүл ахуй, халдвар хамгааллын дэглэм, эм эмнэлгийн хэрэгслийн чанар, аюулгүй байдлын чиглэлээр хэрэгжиж буй дүрэм журмын биелэлт, үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн судалгаа зэрэгт хяналт хийж, зөвлөгөө, зөвлөмж өгөн, илэрсэн зөрчлүүдийг арилгасан тайлан ирүүлэхийг хүссэн байна. Гэвч чанарын албаны дарга Д.Уянга аудитын хугацаанд сургалтад явсан, ажлаасаа гарч байгаа зэрэг шалтгаанаар ирээгүй ба зөвлөмжийн хэрэгжилтийг эргэн шалгасан, шалгалтын үр дүнг тооцсон, гарсан зөрчил дутагдлыг арилгах талаар ямар арга хэмжээ авсан эсэхийг нотлох баримт байхгүй байна.

Иймд байгууллагын дотоод хяналтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгах талаар авч байгаа арга хэмжээ, түүний үр дүн хангалтгүй гэж үзэж байна.

4.2. Санхүүгийн хяналт, аудитын албанаас өгсөн зөвлөмжийн биелэлт 42.8 хувьтай байна.

Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газраас тус эмнэлгийн 2016, 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд баталгаажуулах аудит хийсэн. Аудитаар:

- Өвчтөн тээвэрлэсэн шатахууныг үйлчлүүлэгчээс болон байгууллагаас давхардуулан авсан,
- Сахилгын шийтгэлтэй 2 ажилтанд урамшуулал олгосон,
- ЭМНДХ-ийн актын төлбөрийг төсвийн хөрөнгөөс барагдуулсан зэрэг зөрчлүүд илэрч, нийт 3.3 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоосныг төлж барагдуулсан байна.

Санхүүгийн хяналт, аудитын албанаас 2017 онд Нэгдсэн эмнэлгийн 2015-2016 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт, шалгалтыг явуулж, гэрээт

ажиллагсдад илүү цалин олгосон, илүү цагийн хөлсийг үндсэн ажлын албан тушаалын цалингаас тооцсон, цалин ээлжийн амралтыг давхардуулан олгосон, төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан зэрэг зөрчилд 13.3 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 7 зөвлөмж өгчээ. Тухайлбал: Ажлын уялдаа, хариуцлагыг сайжруулж ажиллах, илүү цагийн хөлсийг ажлын байрны үндсэн цалингаас тооцох, дотоод хяналт шалгалтыг чанаржуулах, санхүү бүртгэлийн ажилтныг тогтвор суурьшилтай ажиллуулах, тэдэнд ур чадварын нэмэгдлийг хууль тогтоомжид заасны дагуу олгох, төлбөртэй үйлчилгээний орлогыг тайлан тэнцэлд бүрэн тусгах, шилэн дансны цахим системд мэдээллийг хугацаанд нь оруулж хэвших гэх мэт.

Аудитын явцад төлбөрийн актын барагдуулалт болон зөвлөмжийн хэрэгжилттэй танилцахад актын төлбөрөөс 799.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй, зөвлөмж 42.8 хувийн биелэлттэй байлаа.

Өгөгдсөн зөвлөмжүүдээс дотоод хяналт шалгалтыг чанаржуулах, шилэн дансны цахим системд мэдээллийг оруулж хэвших, санхүү бүртгэлийн ажилтнуудад ур чадварын нэмэгдлийг хууль тогтоомжид заасны дагуу олгох, илүү цагийн хөлсийг ажлын байрны үндсэн цалингаас тооцох гэсэн 4 зөвлөмж хэрэгжээгүй байна.

4.3. Нэгдсэн эмнэлэг 2018 оны 457.4 сая төгрөгийн мэдээллийг шилэн дансанд байршуулаагүй байна.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг УАГ-ын нэгдсэн төлөвлөгөө, удирдамжийн дагуу 2016, 2017 онуудад хийж гүйцэтгэсэн тул тус аудитаар 2018 оны 1-5 дугаар сарыг хамрууллаа. Уг хуулийн хэрэгжилтийг шалгахад хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5¹-д цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 457.4 сая төгрөгийн 7 гүйлгээг мэдээлээгүй байв. Мөн хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8²-д заасан төсөв, өмч хөрөнгө, мөнгө зарцуулахтай холбоотой 26.1 сая төгрөгийн 11 тушаал шийдвэрээс 21.3 сая төгрөгийн 6 тушаал шийдвэрийг байршуулаагүй байна. Уг зөрчлийг засуулахаар албан шаардлага хүргүүлээ.

Дээрхээс бусад мэдээллүүдийг хугацаанд нь бүрэн байршуулсан байв.

¹ Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр

² Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр

АУДИТЫН ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг өгч байна.

1. Төсвийн орлого, зарлагыг үндэслэлтэй төлөвлөж, батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулжээ.
2. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлэх орчин нөхцөл, хүний нөөцийн хүрэлцээ зохих түвшинд хангагдсан боловч зарим шаардлагатай тоног төхөөрөмжүүд дутагдалтай байна.
3. Амбулаторийн үзлэгийн цаг олголт ажлын цагийн хуваарийн дагуу олгогдохгүй байна.
4. Хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, ашиглалтын байдал хэвийн байна.
5. Байгууллагын дотоод хяналт үр дүнгүй байна.

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Аудитын дүнд үндэслэн дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг доорх албан тушаалтнуудад зөвлөж байна.

Нэгдсэн эмнэлгийн дарга Б.Эрдэнэтулгад:

- Эмийн зардлын төсвийг хүрэлцэхүйц хэмжээгээр батлуулахад анхаарах
- Эмчилгээ эрхэлсэн орлогч, хүний нөөцийн менежер, чанарын албаны дарга нарын тасгуудад жижүүр хийсний илүү цагийн хөлсийг эмчийн албан тушаалын цалингаас тооцож олгохоор хөдөлмөрийн гэрээ болон жижүүр эмчийн ажиллах журамд тусгаж олгох
- Амбулаторийн үзлэгийн цаг олголтыг ажлын цагийн хуваариар бүрэн олгох
- Ажиллагсдын ажлын цагийн бүртгэлийг цахимжуулах
- Амбулаториор үйлчлүүлж байгаа иргэдэд 13.00-16.30 цагуудад үзүүлэх боломж байгаа талаар мэдээллийг сайтар сурталчлах
- Байгууллагын дотоод хяналтыг чанаржуулж, түүний үр дүнг дээшлүүлэх
- Шилэн дансанд мэдээллийг бүрэн байршуулж байх

Аудитаар илэрсэн зөрчил дутагдалд дүгнэлт хийж, төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг гаргаж, 2018 оны 12 дугаар сарын 20-ны дотор Дархан-уул аймаг дахь Төрийн Аудитын газарт ирүүлэх

ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

2018.08.31.